

## **2021 ОНЫ 2-Р САРЫН 27-ООС СУРГУУЛЬ, СУРГУУЛИЙН БАЙГУУЛЛАГУУДЫН АШИГЛАЛТЫН МЭДЭЭЛЭЛ**

**Засгийн газар 2021 оны 2-р сарын 26-ны өдрийн хуралдаанаар өнөөгийн тархалтын онцгой нөхцөл байдлын улмаас 2021 оны 2-р сарын 27-ны өдрөөс эхлэн сургууль ба сургуулийн байгууламжийн үйл ажиллагаанд цаашдах өөрчлөлт хийх тухай шийдвэрлэв.**

Боловсрол, залуучууд ба спортын яамнаас мэдээлснээр эпидемиологийн таагүй нөхцөл байдлын улмаас 2021 оны 2-р сарын 26-ны өдөрт Чехийн засгийн газар нь 200 тоот **Хямралын арга хэмжээг** (ЭНД байгаа) батлаж, одоо хэрэгжүүлж буй арга хэмжээнүүдээс гадна:

**ХУВЬ ХУНИЙ ОРОЛЦООГ ХОРИГЛОНО:**

- хүүхдийн цэцэрлэгт хүүхдүүд
- бэлтгэл ангийн хүүхдүүд
- бага сургуулийн 1, 2-р ангийн суррагчид
- бага ангийн суррагчид, хэрэв 1 буюу 2-р ангийн суррагчидтай хамт нэг ангид хамрагдаж байвал
- тусгай бага сургуулийн бэлтгэлийн үе шатанд байгаа хүүхдүүд
- Боловсролын тухай хуулийн 16-р зүйлийн 9-р заалтын дагуу байгуулагдсан бага сургуулийн эсвэл ангиудын суррагчид
- нэг жилийн Практик сургууль ба хоёр жилийн Практик сургуульд боловсролын үүрэгтэй суррагчид
- тодорхой онцгой тохиолдолд үйл ажиллагаа явуулж болох зөвшөөрөлтэй байсан сургуулийн клуб ба хичээлийн бус цагийн сургуулийн бүлгэмийн суррагчид

Бага ба дунд сургуулиуд нь эдгээр хүүхдүүд буюу суррагчдад алсын зайны боловсрол олгоно. Цэцэрлэг нь сургуулийн өмнөх боловсрол заавал эзэмших үүрэгтэй хүүхдүүдэд алсын зайны боловсрол олгоно. Ирэх долоо хоногийн эхээр хүүхдүүдийн алсын зайнанас сургах арга барилын материалыг цэцэрлэгүүдэд явуулна.

2-оос 10 хүртэл насны хүүхдийн хууль ёсны төлөөлөгчид нь төрийн үйл ажиллагаанд шаардлагатай мэргэжлээр ажиллаж байвал, тэдний хүүхэд нь заагдсан сургуульд ба сургуулийн байгууллагад явж болно, 2021 оны 2-р сарын 26-ны өдөрт гарсан 212 тоот **Хямралын арга хэмжээг** үзнэ үү (ЭНД дарна уу).

**СУВИЛГААНЫ ТӨЛБӨР:** эцэг эхчүүд сувилгааны талаархи мэдээллийг эндээс авах боломжтой, жишээлбэл: <https://www.cssz.cz/web/cz/aktualni-informace-k-osetrovnemu>. Шинэ дүрмийн дагуу сургууль ямар ч баталгаа өгөхгүй болсон.

**ХУВЬ ХУНИЙ ОРОЛЦОО ЦААШИД НЬ ЗӨВШӨӨРӨГДӨНӨ:**

- эмнэлгийн байгууллагын хүүхдүүд цэцэрлэгт хамрагдах
- эмнэлгийн байгууллагын бага ангийн суррагчид
- байгууллагын боловсрол буюу хамгааллын боловсрол олгох зорилгоор байгуулагдсан сургуулийн суррагчид
- Хууль зүйн яамнаас байгуулагдсан сургуулийн суррагчид
- эмнэлгийн байгууллагад ба нийгмийн үйлчилгээний байгууллагад анагаах ухааны чиглэлийн суррагчид ба оюутнууд нь практик аргаар сургалт ба практик дадлага хийж болно
- хүүхдүүд, суурь боловсрол эзэмшиж буй суррагчид, мэргэжлийн дунд болон дээд боловсролын сургуулийн суррагчид, оюутнууд ганцаарчилсан зөвлөлдөх цагт оролцож болно.

## **ЗӨВШӨӨРӨГДСӨН НЬ ЦААШИД ХЭВЭЭР БАЙНА:**

- элсэлтийн шалгалт, төгсэлтийн шалгалт, сургууль төгсөх шалгалт, төгсгөлт, олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн шалгалтууд, хүний тоог хязгаарлахгүй байх
- дээд мэргэжлийн сургуулиудад дээд тал нь 10 хүний оролцоотой шалгалт өгөх
- ерөнхий боловсролын сургууль, консерваториудад комиссын залруулга, комиссын орлуулах шалгалтыг зохион байгуулах
- Чехийн нутаг дэвсгэрт өөр оршин суугаа газаргүй сурагчид ба оюутнууд, хямралын арга хэмжээний дагуу өдрийн ангид хамрагдах оюутнуудыг сургуулийн боловсролын болон байрлах байранд байрлуулах,
- улсын хэлний шалгалтыг дээд тал нь 10 хүний оролцоотой явуулна

**Сум хоорондын шилжилт хөдөлгөөний ерөнхий хоригоос гадуур бусад онцгой тохиолдол байдаг, үүний дотор дадлага хийх ба шалгалт өгөх нь боловсролын зорилготой аялал болно. Тэгвэл хямралын арга хэмжээний дагуу ийм зорилготой сургалт (дадлага) эсвэл шалгалтанд хамрагдах аялал нь онцгой тохиолдол болж, цаашид ч гэсэн зөвшөөрөгдөж байна. 15-аас доошгүй насанд хүрсэн бусад хүн энэхүү онцгой тохиолдлыг хэрэглэж байвал, бичгээр бичсэн баримт бичиг эсвэл үнэнч мэдээлэл үзүүлж, ашигласан үндэслэлээ ил тод тодорхой нотлох шаардлагатай байна. **2021 оны 2-р сарын 26-ны өдөрт гарсан 216 тоот Хямралын арга хэмжээг (ЭНД байгаа) үзэж болно.****

Эх сурвалж: <https://www.msmt.cz/skoly-rezim-od-brezna>

2021 оны 3-р сарын 2-ны өдрийн хувилбар